



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 9 сарын 18 едөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Г Эмнэлгийн тусlamж үйлчилгээний шатлал, шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцооны загвар батлах тухай

Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн тусlamж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1 Эмнэлгийн тусlamж үйлчилгээний шатлалын тухай нэгдүгээр, шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцооны загварыг хоёрдугаар, шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгч шилжүүлэхэд хэрэглэх эмчээс эмчид илгээх захидалын маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2 Энэ тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутаг, байгууллагын нөөц бололцоог ашиглан шийдвэрлэж, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3 Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/308, 2000 оны 225 тоот тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

4 Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээний газар (С.Энхболд)-т даалгасугай.



С.ЛАМБАА



Эрүүл мэндийн сайдын 2009 оны 9 сарын
/8.. өдрийн тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлалын тухай

Нэг. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлал

- 1.1 Монгол улсын эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлалын тогтолцоо нь эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээнд суурилсан анхан, хоёрдогч, гуравдагч гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй байна.
- 1.2 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагууд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дээрх 3 шатлалд хуваагдан, тухайн тусгай зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэрийнхээ хамрах хүрээнд тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3 Энэхүү тушаалд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

 - 1.3.1 “өрхийн эмнэлэг” гэж хот суурин газрын бүртгүүлсэн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий хувийн хэшлийн хуулийн этгээдийг;
 - 1.3.2 “сумын эмнэлэг” гэж сумын хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн өмчийн хуулийн этгээдийг;
 - 1.3.3 “сум дундын эмнэлэг” гэж өөрийн харьяа нутаг дэвсгэрийн болон зэргэлдээ сумдын хүн амд анхан шатны болон үндсэн мэргэжлийн зарим тусlamж, үйлчилгээг үзүүлэх төрийн өмчийн хуулийн этгээдийг;
 - 1.3.4 “эрүүл мэндийн төв” гэж хот суурин газрын хүн амд 5-аас доошгүй чиглэлээр үндсэн мэргэжлийн тусlamж, үйлчилгээг амбулаторийн хэлбэрээр үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг хүн амд хүргэх үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
 - 1.3.5 “нэгдсэн эмнэлэг” гэж хүн амд 6-аас доошгүй чиглэлээр үндсэн болон төрөлжсэн мэргэжлийн тусlamж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
 - 1.3.6 “бүсийн оношлогоо, эмчилгээний төв” гэж бүс нутгийн хүн амд эрүүл мэндийн үндсэн болон төрөлжсэн мэргэжлийн лавлагаа тусlamж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа, судалгаа хийх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

- 1.3.7 “төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төв” гэж улсын хэмжээнд, хүн амд төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 1.3.8 “төрөлжсөн мэргэжлийн төв” гэж бүх насны, эсвэл тодорхой бүлгийн хүн амд төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 1.3.9 “оношлогоо, эмчилгээний төв” гэж хүн амд 10-аас доошгүй чиглэлээр үндсэн бөгөөд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өндөр технологи бүхий оношлогоо, лабораторийн үйлчилгээтэй хослуулан амбулаторийн хэлбэрээр үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 1.3.10 “рашаан сувилал” гэж эмчлэн сэргийлэх зорилгоор ашиглаж байгаа байгалийн эмчилгээний нөөцтэй, тусгай хамгаалалттай дэвсгэр нутагтай, барилга байгууламж, тоног төхөөрөмж, мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн бүхий хуулийн этгээдийг;
- 1.3.11 “сувилал” гэж бүх насны эсхүл тодорхой бүлгийн хүн амд сувилах, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 1.3.12 “үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ” гэж дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, халдвартын мэргэжлээр үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлогоо, эмчилгээний зориулалтын үйлдэл, ажилбар хийх, мэргэжлийн дүгнэлт гаргах, өвчтөнийг оношлох, эмчлэх, сувилах, хянах, нөхөн сэргээх, яаралтай тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх хөтөлбөрт үйл ажиллагаанд оролцох, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох цогц үйл ажиллагааг;
- 1.3.13 “төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ” гэж үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээнээс гадна зүрх судас, чих хамар хоолой, нүд, мэдрэл, сэтгэц, хавдар гэх мэт төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлогоо, эмчилгээний зориулалтын үйлдэл, ажилбар хийх, мэргэжлийн дүгнэлт гаргах, өвчтөнийг оношлох, эмчлэх, хянах, нөхөн сэргээх, яаралтай тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх хөтөлбөрт үйл ажиллагаанд оролцох, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох цогц үйл ажиллагааг.

Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд хамаарах эрүүл мэндийн байгууллагууд, үзүүлэх тусламж үйлчилгээ.

2.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага гэдэг нь тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн

анхан шатны тусламж, үйлчилгээг батлагдсан удирдамж, стандартын дагуу харьяа нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тогтолцооны анхан шатны нэгж байгууллага мөн.

2.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаад сум, өрх, тосгон, сум дундын эмнэлэг, орон нутгийн нэгдсэн эмнэлэг зэрэг хамаарна.

2.3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь өрхийн ба сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангасан байна.

2.4. Сум дундын эмнэлэг, орон нутгийн нэгдсэн эмнэлэг нь газар зүйн байршил, хүн амын нягтралаас хамааран нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцаас гадна мэс засал, дотор, мэдрэлийн чиглэлээр нэмэлт тусламж, үйлчилгээний багцын хүрээнд эмнэлзүйн удирдамж, стандартад заасны дагуу анхан болон үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг бусад сумын эмнэлгээс илгээсэн үйлчлүүлэгчдэд үзүүлнэ.

2.5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь дээд шатлалын эмнэлгээс буцааж илгээсэн үйлчлүүлэгчдэд үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн гаргасан зөвлөмжийн дагуу тусламж, үйлчилгээг үзүүлж, хяналтандaa авна.

2.6. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага гэдэг нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас шилжүүлсэн бүх насын үйлчлүүлэгчдэд эмнэлзүйн удирдамж, стандартад заасны дагуу тусламж, үйлчилгээний нэмэлт багцын хүрээнд дотор, мэдрэл, ерөнхий мэс засал, гэмтэл, эх барих, эмэгтэйчүүд, сэтгэц, нүд, чих хамар хоолой, хавдар, халдварт өвчний чиглэлээр үндсэн болон зарим төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэг дор үзүүлэх чадавхи бүхий нэгдсэн эмнэлгийн бүтэцтэй эрүүл мэндийн тогтолцооны хоёрдогч шатны нэгж байгууллага мөн.

2.7. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагад бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл, төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэг, амаржих газар, аймаг, нийслэлийн хэмжээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал, оношлогоо, эмчилгээний төв зэрэг хамаарна.

2.8. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, анагаах ухааны сургалт, эрдэм шинжилгээний ажлыг тухайн орон нутгийн түвшинд гүйцэтгэх үүрэгтэй ажиллана. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв нь харьяалах бүсийн аймгийн нэгдсэн эмнэлэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн эмч нарын үзлэг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллана.

2.9. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв нь бүсийн хэмжээнд үйлчлэх хүрээний хүн амд аймгийн нэгдсэн эмнэлэгт хийгддэггүй, оношлогдоогүй, эмчилгээний үр дүнгүй болон яаралтай тусламж, ерөнхий мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, дотор, нүүр


ам судлал, сэтгэц, бөөр, шээсний замын эмгэг, чих хамар хоолой, гэмтэл согог, нүдний өвчний тохиолдлуудад үндсэн болон зарим төрөлжсөн мэргэжлийн тусlamж, үйлчилгээг эмнэлзүйн удирдамж, стандартад заасны дагуу үзүүлнэ.

2.10. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага гэдэг нь хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагаас шилжүүлсэн үйлчлүүлэгчдэд (хүүхэд, насанд хүрэгч) эмнэлзүйн удирдамж, стандартад заасны дагуу тусlamж үйлчилгээний нэмэлт багцын хүрээнд зүрх судас, уушиг, цус, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, үе мөч, мэдрэл, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, сэтгэц, нүд, чих хамар хоолой, нүүр ам судлал, хавдар, халдварт өвчний чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусlamж, үйлчилгээг нэг дор үзүүлэх чадавхи бүхий нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвийн бүтэцтэй эрүүл мэндийн тогтолцооны гуравдагч шатны нэгж байгууллага мөн.

2.11. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг, улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн нэгдсэн эмнэлэг, оношлогоо, эмчилгээний төв, рашаан сувилал зэрэг хамаарна.

2.12. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага нь хоёрдогч шатлалын эмнэлэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд тусlamж, үйлчилгээний чиглэл тус бүрээр төрөлжсөн мэргэжлийн үзлэг, зөвлөгөө хийнэ.

2.13. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага нь төрөлжсөн мэргэжлийнхээ чиглэлээр бусад эмнэлэгт үзлэг, зөвлөгөөг өгөх эмч, эмнэлгийн мэргэжилтний ажиллах хуваарийг эмнэлгийн дарга, захирал нарын хамтарсан тушаал, гэрээгээр зохицуулан ажиллана.



Эрүүл мэндийн сайдын 2009. оны 9 сарын
18. өдрийн 10 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх загвар

Нэг. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх загвар

- 1.1. Энэхүү журмыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх бүх шатны эрүүл мэндийн байгууллага хооронд яаралтай бус тохиолдолд үйлчлүүлэгч шилжүүлэх харилцааг зохицуулахад дагаж мөрдөнө.
- 1.2. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангаж, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан тусlamж, үйлчилгээнийхээ шатлал, чиглэл, төрлийн хүрээнд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явцад оролцно.
- 1.3. Эрүүл мэндийн байгууллагын шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх явцыг тасралтгүй, чирэгдэлгүй байдлаар зохион байгуулна.
- 1.4. Тухайн эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчийн онош тодорхойлогоогүй, шаардлагатай оношлогоо, эмчилгээг хийх чадавхи дутагдалтай, онош тодорхой боловч эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлнэ.
- 1.5. Эрүүл мэндийн байгууллагын шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явц нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас хоёрдогч шатлалд, хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагаас гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагад гэсэн дараалалтай байна.
- 1.6. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үйлчлүүлэгчийг хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагад эсвэл шууд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад шилжүүлнэ. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад шилжүүлнэ.
- 1.7. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэхдээ “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас” 13 А, Б маягтын хамтаар үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн дэвтэрт шаардлагатай бичилтийг (өвчний түүх, шинжилгээний дүн, хийгдсэн эмчилгээ г.м) дэлгэрэнгүй хийсэн байна.
- 1.8. Эмчлэгч эмч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн тусlamж үйлчилгээний талаарх санал, зөвлөгөө болон бусад мэдээллийг шилжүүлж буй

эмчид хүргэх зорилгоор “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас”, эрүүл мэндийн дэвтэр дэх бичилтээс гадна “Эмчээс эмчид илгээх захидал”-ыг бичиж явуулна.

1.9. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийн талаар мэдээлэл дамжуулахдаа цаасан, утсан холбооны болон цахим хэлбэрийг өргөнөөр ашиглана.

1.10. Эмнэлгийн яаралтай тусlamж шаардлагатай, үйлчлүүлэгчийн амь насанд аюултай тохиолдолд өмчийн хэлбэр болон шатлал харгалзахгүйгээр хамгийн ойрын эмнэлэгт зохих тусlamж үйлчилгээг илгээх хуудас шаардахгүйгээр үзүүлнэ.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явц

2.1. Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага нь өөрийн үзүүлж буй тусlamж үйлчилгээний төрлийн жагсаалт, чадавхийн талаарх мэдээллийг дээд болон доод шатлалын эрүүл мэндийн байгууллагад төдийгүй үйлчлүүлэгчдэд нээлттэй, ил тод байдлаар байнга хүргэх арга хэмжээг цахим ба цаасан хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулж ажиллана.

2.2. Анхан шатны ба хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагууд нь үйлчлүүлэгч шилжүүлэх, уялдаа холбоог нь сайжруулах, анхан шатны тусlamжийн “хаалга барих” үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд үр дүнтэйгээр зохион байгуулах арга зам, төлөвлөгөөг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар баталгаажуулан ажиллана.

2.3. Анхан шатны ба хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд үйлчлүүлэгчдэд мэдээлэл хүргэх арга хэлбэр, өөрийгөө илгээсэн үйлчлүүлэгчийн тоог цөөрүүлэх, анхан шатны байгууллагад шилжүүлэх хяналт, зөвлөгөөг хэрэгжүүлж буй эмч, эмнэлгийн ажилтнуудын гүйцэтгэлийг дүгнэх, урамшуулах асуудлыг тусгасан байна.

2.4. Хамтын ажиллагааны төлөвлөгөөнд эрүүл мэндийн байгууллагын шатлал хоорондын хамтарсан уулзалтыг үучилсэн байдлаар зохион байгуулах арга хэмжээг тусган оруулна.

2.5. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч шилжүүлэхдээ засаг захиргааны харьяалал харгалзахгүй тул үйлчлүүлэгчийг сонгосон эмнэлэгт нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас” маягтыг бичиж илгээнэ.

2.6. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага нь тухайн үйлчлүүлэгчид шаардлагатай тусlamж, үйлчилгээг бүрэн үзүүлээд цаашдын эмчилгээ, үйлчилгээний талаарх зөвлөмжийн хамтаар өвчтөнг буцаан илгээх хуудсыг бичиж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчид явуулна.

2.7. Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч нь тухайн үйлчлүүлэгчид шаардлагатай тусlamжийг үзүүлэх чадавхи бүхий гуравдагч шатлалын эмнэлэгт засаг захиргааны харьяалал харгалзахгүйгээр үйлчлүүлэгчийг “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас” маягтыг бичиж илгээнэ.

2.8. Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч нь цаашид үйлчлүүлэгчид шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний талаарх зөвлөмжийн хамтаар өвчтөнг буцаан илгээх хуудсыг бичиж, хоёрдогч шатлалын эсвэл анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчид явуулна.

2.9. Яаралтай бус тохиолдолд гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх шаардлага гарсан бол шилжүүлж буй эмч "Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас" маягтыг шинээр бичиж, хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үйлчлүүлэгчид олгосон илгээх маягтын хуулбарын хамтаар үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн дэвтэрт дэлгэрэнгүй бичилт хийж явуулна.

2.10. Дараахь тохиолдлуудад үйлчлүүлэгчийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас шууд гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээж болно.

- a. Гуравдугаар шатлалын төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт эмчлэгдэх өвчний онош нь тодорсон;
- b. Урьд нь гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагад онош нь тодорхойлогдож эмчлэгдээд, тодорхой хугацааны дараа дахин ирж эмчлүүлэхийг зөвлөсөн.

2.11. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгч шилжүүлгийн байдалд хөндлөнгийн аудитыг жил тутам хийлгэж байна.

2.12. Үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагааг зохицуулах журам болон хэвтүүлэн эмчлэх шалгуур үзүүлэлтийг эмнэлэг бүр өөрийн үзүүлж буй тусlamж үйлчилгээний төрөл, хэрэгжиж байгаа өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамжид заасантай нийцүүлэн боловсруулж мөрдөн ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2009. оны 1. сарын
10-төд тушаалын гуравдугаар хавсралт

Үйлчлүүлэгч шилжүүлэхэд эмчээс эмчид илгээх захидалын загвар¹

Илгээгч/ зөвлөгөө өгөгч талын мэдээлэл	
Эрүүл мэндийн байгууллагын нэр	
Илгээж/зөвлөгөө өгч буй эмчийн нэр	
Утас, цахим шуудангийн хаяг	
Үйлчлүүлэгчийн тухай мэдээлэл	
Овог,нэр	
Илгээж буй зорилго	
Өвчлөлийн талаарх мэдээлэл	
Үйлчлүүлэгчийн онош	
Үзлэг, шинжилгээгээр илэрч буй өөрчлөлтүүд	
Хийгдсэн эмчилгээ	
Цаашид шаардлагатай тусlamж үйлчилгээний талаарх зөвлөгөө	
Илгээгч/зөвлөгөө өгөгч эмчийн гарын үсэг	
Холбоо барих утас, цахим шуудангийн хаяг	

¹ Зөвхөн шаардлагатай тохиолдолд эмчлэгч эмч бичиж явуулна